

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гаалийн ерөнхий газар

Хорио цээрийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Цөмийн болон цацрагийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч

Дэс түшмэл, ТТ-5

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 81/1

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу гаалийн хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн хууль бус хөдөлгөөнд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн бодлого, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган биелэлтэд хяналт тавих чиг үүргийг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Гаалийн хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд эрсдэлд суурилсан цөмийн болон цацрагийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн хууль бус хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, удирдамж, чиглэлээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих, цацрагийн хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, салбарын хяналт шалгалтын бодлого, төлөвлөлт, гүйцэтгэлийг мэргэжлийн үндсэн дээр удирдах, бодлогын болон арга зүйн зөвлөгөө, нэгдсэн удирдамжаар хангах;
2. Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой Олон улсын гэрээ, конвенц, салбарын хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд тавьсан хяналт шалгалтын талаарх нэгдсэн мэдээллээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагыг хангах, салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал хүргүүлэх, цацрагийн хамгаалалт аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
3. Гаалийн харилцаанд оролцогч төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
4. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх - Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Гаалийн хилээр нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд цөмийн болон цацрагийн хяналт шалгалт хийх, хууль бус хөдөлгөөний таслан зогсоох, сэжигтэй /дохиолол/ тохиолдол илэрсэн үед холбогдох байгууллагатай хамтран хариу арга хэмжээг авах, цацрагийн хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах;	НҮБ-ын 1540 тогтоол, олон улсын гэрээ, конвенц болон Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй цөмийн материал цацрагийн үүсгүүрийн бүртгэл хяналт хийгдсэн байна.	Г, Х
	2. Улсын хил дээр суурилуулсан цацрагийн хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх, нөөц сэлбэг хэрэгслийг бүрдүүлэх, дохиолол мэдээллийн бүртгэл хөтлөх;		Г, Т
	3. Цацрагийн хяналтын нэгдсэн дохиолол мэдээллийн төвийн ажиллагааг хэвийн явуулах ажлыг зохион байгуулах, хяналт шалгалтыг давхар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;		Г
	4. Улсын хил дээр суурилуулсан цацраг илрүүлэх төхөөрөмжийн өдөр тутмын тоон мэдээллийг DART		



	программ ашиглан дүн шинжилгээ хийж үр дүнг тооцох;		
	5. Орон нутгийн цөмийн болон цацрагийн хяналтын чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч нарыг хяналт шалгалт хийх үйл ажиллагааны чиглэл, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, сургаж, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;		Г
	6. Хилийн нэвтрэх цэгт болзошгүй гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед холбогдох дүрэм, журмын дагуу ажиллах.	Болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлж хариу арга хэмжээг оновчтой төлөвлөсөн байна.	Г, Т
2 дугаар зорилтын хүрээнд	1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;	Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан байдал үр дүн.	Г, Т
	2. Цөмийн болон цацрагийн хяналт, шалгалттай холбоотой асуудлаар гаалийн харилцаанд оролцогчдод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;	Гадаад худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдлэг дээшилж бизнесийн өсөлтөд дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Т
	3. Гаалийн хилээр нэвтэрч буй цөмийн материал, цацрагийн үүсгүүр хяналт шалгалт хийх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангах, хяналт шалгалтын үйл ажиллагааг зохицуулсан журам, зааврыг боловсруулах, батлуулах, боловсронгуй болгох чиглэлээр бусад газар хэлтэстэй хамтран ажиллах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Г
	4. Цөмийн энергийн тухай хуулийн дагуу гаалийн байгууллагын рентген төхөөрөмжүүдийн импортлох, ашиглах, хадгалах тусгай зөвшөөрлийн материалын бүрдүүлэн холбогдох байгууллагаас авах;		



	5. Гаалийн байгууллагад ашиглагддаг рентген төхөөрөмжүүдийн цацрагийн хамгаалал, аюулгүй байдлын холбогдолтой дүрэм, журам, стандарт боловсруулан батлуулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх;		Г, Х
	6. Хяналт шалгалтын дүнд тулгуурлан эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санал боловсруулж зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдлыг хянан үзэж, шийдвэрлэх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г
	2. Хяналт шалгалтын үр дүнг "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам" болон холбогдох журмын дагуу олон нийтэд мэдээлэх, сурталчлах;	Зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлсэн байна.	Г
	3. Салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг боловсронгуй болгох асуудлаар холбогдох байгууллагад санал боловсруулж хүргүүлэх, хамтран ажиллах;	Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын шаардлага холбогдох эрхзүйн зарчимд нийцсэн байна.	Г, Т
	4. Гадаад худалдаанд техникийн саад, тотгор учруулж буй хууль тогтоомж, стандартыг боловсронгуй болгох асуудлаар холбогдох байгууллагад санал боловсруулж хүргүүлэх, хамтран ажиллах;	Худалдааг хөнгөвчлөхөд саад учруулж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх саналыг хүргүүлсэн байна.	Г,Т
	5. Шаардлагатай тохиолдолд хилийн боомтын гаалийн хяналт шалгалтын бүсэд баригдах барилга байгууламжийн зураг төсөлд рентген төхөөрөмж болон цацрагийн төхөөрөмжийн байршлыг тусгаж урьдчилсан болон гүйцэтгэлийн хяналт тавих.	Барилга байгууламж зураг төслийн дагуу баригдсан байна.	Г, Х
1. Ажил үүргийн хуваарийн дагуу гүйцэтгэх үйл ажиллагаанд эрсдэл тооцож, хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	Гүлс	
2. Гаалийн ерөнхий газрын зохион	Хэрэгжүүлсэн	Г	



4 дүгээр зорилтын хүрээнд	байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодтой цөмийн болон цацрагийн хяналттай холбоотой асуудлаар хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;	арга хэмжээний тоо, үр дүн	
	3. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Т, Г
	4. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл боловсруулах;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	Г
	5. Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой программ хангамжийг боловсронгуй болгох санал өгөх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Физик (0533),</li> <li>- цөмийн технологи (071313),</li> <li>- цөмийн инженерчлэл (071312).</li> </ul>	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;</li> <li>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;</li> <li>- байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх;</li> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, харьцуулсан судалгаа хийх;</li> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах;</li> <li>- мэдээлэлд тулгуурлан хууль тогтоомжийн дагуу тодорхойлсон чиг үүргийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ, хийх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.</li> </ul>



Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- сэтгэн бодох, анализ хийх, хөрвөх чадвартай байх;</li> <li>- өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- албан тушаалын чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох;</li> <li>- удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг.</li> </ul>
Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах.</li> </ul>
Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- гадаад худалдаа, гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцан, өөрийгөө хөгжүүлэх;</li> <li>- төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан;</li> <li>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, гаалийн харилцаанд оролцогчидтой харилцах.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хорио цээрийн хэлтсийн дарга, Гаалийн улсын ахлах байцаагч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:



- Төрийн байгууллагын холбогдох ажилтан;
- Гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд;
- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хорооны дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан.



**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<p><u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u></p>	<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></p>
<p><u>Албан тушаал:</u> ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ..... Ч. ТАМИРАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2023 оны 4 сарын 11-ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 23 03 09 Дугаар: 060</p>

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

<p><u>Байгууллагын нэр:</u> ГААЛИЙН БРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: ..... Дугаар: ..... (тамга/тамдэг) ДАРГА..... Р.ОТГОНЖАРГАЛ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2023 оны 01 дугаар сарын 11-ны өдөр</p>	 
---	---